



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017. 02. 22 № 3/281
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн яамны аппаратын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Зам, тээврийн хөгжлийн яамны аппаратын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт(УСНББОУС)-ын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт(УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн Сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын Олон Улсын Стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.


Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Зам, тээврийн хөгжлийн яамны аппаратын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн Сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ АППАРАТЫН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Аудитын тайлан

Санхүүгийн аудитын
газрын дарга Ц.Наранчимэг
Цахим хаяг:
Naranchimegts@audit.gov.mn
Утас: 261663

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2 Аудитын тайлан

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Аудитын менежер Я.Самбууням
Цахим хаяг:
Sambuunyamy@audit.gov.mn
Утас: 260512

Ахлах аудитор Н.Батсайхан
Аудитор Б.Сэржмядаг
Аудитор Н.Нямдаваа

Утас: 260512

Үндэсний аудитын газар
Засгийн газрын IY байр
Бага тойруу 6
Ула Цахим хуудас: www.audit.mn
Монгол улс

2017 оны 2 дугаар сар

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдлыг тооцсон тухай
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яамны аппаратын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ./ҮАГ-2017/165/СТА-ТШЗ/

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон Улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Зам, тээврийн хөгжлийн яамны аппаратын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн Сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Зам, тээврийн хөгжлийн яамны аппаратын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 2 дугаар сарын 13-наас 2017 оны 2 дугаар сарын 24-ний хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын IV багын ахлах аудитор Н.Батсайхан, аудитор Б.Сэржмядаг, Н.Нямдаваа нар хэрэгжүүлэв.

Зам, тээврийн хөгжлийн яамны аппаратын 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 1 дүгээр сарын 24-нд 03/339 тоот албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн.

Үндэсний аудитын газар аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 24-нд Зам тээврийн хөгжлийн яамны аппаратын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Зам, тээврийн хөгжлийн яамны аппаратын төсвийн захирагч нь Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, Авто замын тухай хууль, Автотээврийн тухай хууль, Иргэний нисэхийн тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, Усан замын тээврийн тухай хууль, Далай ашиглах тухай хууль, Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль, бусад холбогдолтой хууль, эрх зүйн актын дагуу үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, дээрх зарим хуулинд нэмэлт өөрчлөлт орсон.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Зам, тээврийн хөгжлийн яамны эрхэм зорилго нь эдийн засгийн өсөлтийг хангах зам, тээвэр, логиستيкийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай тээврийн үйлчилгээний нөхцөлийг бий болгох явдал мөн.

Тус яам нь улсын хэмжээний зам тээврийн салбарыг хөгжүүлэх улсын хэмжээний бодлогыг хэрэгжүүлэн, түүнийг удирдан чиглүүлэх чиг үүрэгтэйгээр ажиллаж байна

Дээрх зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.4-д “төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу тус яамны Төрийн нарийн бичгийн дарга Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Зам, тээврийн хөгжлийн яамны аппаратын 2016 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Зам, тээврийн хөгжлийн яамны аппаратын үйл ажиллагааны талаар ТАБ-СТА-A-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Зам, тээврийн хөгжлийн яамны аппаратын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлангийн уялдаа тохиргоог шалгаж, мөнгөн гүйлгээний зарим дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорилийг гүйцэтгэв.

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Зам, тээврийн хөгжлийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Зам, тээврийн Сайдын 2013 оны 255 дугаар тушаалаар батлуулан мөрдөж байна. Уг бодлогын баримт бичигт өмнөх оны аудитаар үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцохдоо хүчингүй болсон Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам"-ыг мөрдөж байгаад өөрчлөлт оруулах талаар өгсөн зөвлөмж хэрэгжих шатандаа байна.

Зам, тээврийн хөгжлийн яамны аппаратын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Зам, тээврийн хөгжлийн яамны аппаратын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Санхүүгийн тооцоолох компанийн “Acolous” програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Материаллаг байдлыг тооцсон тухайд:

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг батлагдсан төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэлийг суурь болгон 2 хувиар тогтоож, хүлээн зөвшөөрөх алдааны түвшинг 72.6 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг дахин тооцоолж нийт зардлын 2 хувиар тогтоож, хүлээн зөвшөөрөх алдааны түвшинг 84.4 сая төгрөг гэж тооцов.

Учир нь нийт хөрөнгө, орлогоор тооцоход материаллаг түвшин өндөр гарч байгаа тул тайлант хугацааны үйл ажиллагааг бүхэлд нь хамарсан үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцох нь тохиромжтой гэж үзлээ.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Зам, тээврийн хөгжлийн яамны аппаратын ажлын албаны дотоод хяналт эрсдэлийг бага гэж тооцсон ба дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Зам, тээврийн хөгжлийн яамны аппаратын төсвийн захирагч нь 2016 онд урсгал зардалд 3,631.7 сая төгрөг батлагдсанаас 3,545.3 сая төгрөгийг зарцуулж, батлагдсанаас 86.4 сая төгрөгийг дутуу буюу төсвийн гүйцэтгэл 97.6 хувьтай байна.

Нэмэлт санхүүжилтээр гүүрний засварт 276.0 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитаар 7 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 22 нарийвчилсан горим, сорилыг гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Зам, тээврийн хөгжлийн яамны аппаратын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, завсрын болон жилийн эцсийн аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, төлбөр хураамж, сургалт семинар зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 100 хувь, мөнгөн хөрөнгийн 70 хувь, нийт зардлын 70 хувь, нийт хөрөнгийн 40 хувийг тус тус эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад дараах алдаа, зөрчил илэрсэн. Үүнд:

1. Холбогдох байгууллагын зөвшөөрлөөр 346.1 сая төгрөгийн шилжиж ирсэн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгахдаа тоног төхөөрөмжид 3.3 сая төгрөгөөр илүү, тавилга эд хогшилд 3.0 сая төгрөгөөр дутуу, хуримтлагдсан элэгдэлд 55.2 сая төгрөгөөр дутуу, нийт хөрөнгийг 55.5 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн нь Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төсөвт багууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ыг мөрдөөгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Асуудлыг холбогдох ажилтнуудад танилцуулж, аудитын явцад залруулга хийлгэв.

2. Санхүүгийн тайланд 2012 онд үүссэн эзэн холбогдогч нь тодорхойгүй 1.9 сая төгрөгийн авлага, 5.8 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэл байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна

Шийдвэрлэсэн: Менежментийн захидалд он удаан жил болсон, эзэн холбогдогч нь тодорхойгүй авлага, өр, төлбөрийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэх талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

3. Тайлант онд ХХОАТ-т 8.4 сая төгрөгийг илүү төлж авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн: Менежментийн захидалд тайлант онд суутган тооцооллыг цаг хугацаанд нь үнэн, зөв тооцоолж холбогдох байгууллагад төлж авлага, өр төлбөргүй ажиллах талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

4. Санхүүгийн тайланд 6.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч, шууд зардлаар тайлагнасан нь Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төсөвт багууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ыг мөрдөөгүй, УСНББОУС17 Үндсэн хөрөнгө 13-д а) "Бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний үйлдвэрлэлт буюу нийлүүлэлтэнд, бусдад түрээслэхээр эсвэл захиргааны зориулалтаар ашиглаж буй байгууллагын эзэмшиж байгаа" гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Асуудлыг холбогдох ажилтнуудад танилцуулж, аудитын явцад залруулга хийлгэв.

5. Тайлант онд 42.4 сая төгрөгийн үндсэн, хөрөнгийг бусад зардлын батлагдсан төсвөөс худалдан авч бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидалд батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

6. Тоног төхөөрөмжийн дансанд 2013, 2015 онуудад худалдан авсан 9.9 сая төгрөгийн 1 жилийн хугацаатай ашиглагдах вирусын програмыг бүртгэж элэгдүүлсэн байгаа нь УСНББОУС17 Үндсэн хөрөнгө 13-д б) Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм....." гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидалд үндсэн хөрөнгийн шинжийг агуулаагүй вирусын програмыг зохих журмын дагуу шийдвэрлэх талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитаар нийт 292.8 сая төгрөгийн алдаа илэрснээс 282.9 сая төгрөгийн алдааг залруулж, 9.9 сая төгрөгийн алдааг залруулах талаар зөвлөмж хүргүүлэв.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Сангийн яамнаас техник хяналтын зардлын урьд оны татан төвлөрүүлсэн 5,107.0 сая төгрөгийг буцаан олгосон ба тайлант онд техник хяналтын орлого 1,095.6 сая төгрөг орж 231.4 сая төгрөгийг зарцуулан оны эцэст 4,785.6 сая төгрөгийн үлдэгдлийг буцаан төвлөрүүлж, авлагаар тусгасан байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Зам, тээврийн хөгжлийн яамны аппаратын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

“Зам, тээврийн хөгжлийн яамны аппаратын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 351.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 282.9 сая төгрөгийг санхүүгийн тайланг залруулж, 68.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн төсвийн 2015 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар 72.9 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсний 2-ыг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжүүлэх шатандаа байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Зам, тээврийн хөгжлийн яамны аппаратын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан 8 хуудас, менежментийн захидал 4 хуудсыг тус тус хавсаргав.

Аудитын тайланг

Хянасан:

Санхүүгийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор

Ц.Наранчимэг

Аудитын менежер

Я.Самбууням

Бэлтгэсэн:

Ахлах аудитор

Н.Батсайхан

Аудитор

Б.Сэржмядаг

Аудитор

Н.Нямдаваа



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ АППАРАТЫН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1:

Асуудал 1

Авлага, өр төлбөрийн талаар хуудас 3

Тэргүүлэх ач холбогдол №2:

Асуудал 2

Үндсэн хөрөнгийн талаар хуудас 4

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Зам, тээврийн хөгжлийн яамны аппаратын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Зам, тээврийн хөгжлийн яамны аппаратын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт:

Санхүүгийн тайланд 2012 онд үүссэн эзэн холбогдогч нь тодорхойгүй 1.9 сая төгрөгийн авлага, 5.8 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэл байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, мөн тайлант онд ХХОАТ-т 8.4 сая төгрөгийг илүү төлж авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна

ҮАГ-ын зөвлөмж:

Он удаан жил болсон, эзэн холбогдогч нь тодорхойгүй авлага, өр төлбөрийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэх, тайланд онд суутган тооцооллыг цаг хугацаанд нь үнэн, зөв тооцоолж холбогдох байгууллагад төлж авлага, өр төлбөргүй ажиллах.

Эрсдэл:

- Эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүй байх

Үйлчлүүлэгчийн хариу:

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан болно.

ҮАГ-ын ажиглалт:

Тайлант онд 42.4 сая төгрөгийн үндсэн, хөрөнгийг бусад зардлын батлагдсан төсвөөс худалдан авч бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн, үндсэн хөрөнгийн дансанд 9.9 сая төгрөгийн 1 жилийн хугацаатай ашиглагдах вирусын програмыг бүртгэж элэгдүүлсэн байгаа нь УСНББОУС17 Үндсэн хөрөнгө 13-д б) Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм....." гэсэнтэй нийцэхгүй байна.

Эрсдэл:

- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулахгүй байх

ҮАГ-ын зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, үндсэн хөрөнгийн шинжийг агуулаагүй вирусын програмыг зохих журмын дагуу шийдвэрлэж ажиллах.

Үйлчлүүлэгчийн хариу:

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

[Type here]

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	2015.12.31 Эхний үлдэгдэл	2016.12.31 Эцсийн үлдэгдэл	Залруулга	Аудит хийгдсэн Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,014,079,168.58	4,882,411,823.19	-	4,882,411,823.19
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-	-	-
33	АВЛАГА	3,924,575,802.20	4,798,695,365.11	-	4,798,695,365.11
335	Бусад авлага	3,924,575,802.20	4,790,047,793.33	-	4,790,047,793.33
3351	Байгууллагаас авах авлага	3,924,324,942.20	4,787,547,793.33	-	4,787,547,793.33
3352	Хувь хүмүүсээс авах авлага	250,860.00	2,500,000.00	-	2,500,000.00
34	УРЬДЧИЛГАА	1,306,800.00	1,306,800.00	-	1,306,800.00
34600	Урьдчилж гарсан зардал	1,306,800.00	1,306,800.00	-	1,306,800.00
3471	Урьдчилгаа тооцоо	-	-	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	88,196,566.38	82,409,658.08	-	82,409,658.08
351	Түүхий эд материал	18,127,138.00	23,107,855.70	-	23,107,855.70
35110	Тусгай зориулалттай материал	18,127,138.00	23,107,855.70	-	23,107,855.70
354	Хангамжийн материал	70,069,428.38	59,301,802.38	-	59,301,802.38
35410	Бичиг хэргийн материал	3,378,050.00	4,080,100.00	-	4,080,100.00
35420	Аж ахуйн материал	47,361,905.20	34,370,029.20	-	34,370,029.20
35430	Сэлбэг хэрэгсэл	3,702,000.00	3,702,000.00	-	3,702,000.00
35440	Түлш, шатах тослох материал	324,669.00	324,669.00	-	324,669.00
35470	Бусад хангамжийн материал	15,302,804.18	16,825,004.18	-	16,825,004.18
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,428,199,184.45	2,463,691,378.35	(48,600,563.00)	2,415,090,815.35
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,428,199,184.45	2,463,691,378.35	(48,600,563.00)	2,415,090,815.35
392	Биет хөрөнгө	2,421,240,017.66	2,462,224,711.52	(53,330,563.00)	2,408,894,148.52
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,560,707,579.70	3,560,707,579.70	-	3,560,707,579.70
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,698,507,311.20)	(1,787,658,156.52)	-	(1,787,658,156.52)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	171,370,409.96	321,828,449.96	-	321,828,449.96
39204	Хуримтлагдсан элэгдэл	(30,072,491.07)	(47,209,531.95)	(18,807,255.00)	(66,016,786.95)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	525,095,105.33	605,637,794.33	(3,266,855.00)	602,370,939.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	(274,976,610.19)	(357,757,077.39)	(29,162,660.50)	(386,919,737.89)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	330,861,080.89	367,819,840.89	5,166,655.00	372,986,495.89
39208	Хуримтлагдсан элэгдэл	(163,378,745.76)	(201,285,187.50)	(7,260,447.50)	(208,545,635.00)
39217	Ном	141,000.00	141,000.00	-	141,000.00
393	Биет бус хөрөнгө	6,959,166.79	1,466,666.83	4,730,000.00	6,196,666.83
39301	Програм хангамж	44,309,900.00	44,309,900.00	4,730,000.00	49,039,900.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(37,350,733.21)	(42,843,233.17)	-	(42,843,233.17)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,442,278,353.03	7,346,103,201.54	(48,600,563.00)	7,297,502,638.54
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	37,409,836.00	17,773,604.00	-	17,773,604.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	37,409,836.00	17,773,604.00	-	17,773,604.00
413	Өглөг	37,409,836.00	17,773,604.00	-	17,773,604.00
4136	Бусад өглөг	37,409,836.00	17,773,604.00	-	17,773,604.00
41361	Байгууллагад төлөх өглөг	28,837,246.00	17,773,604.00	-	17,773,604.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	8,572,590.00	-	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,404,868,517.03	7,328,329,597.54	(48,600,563.00)	7,279,729,034.54
51	Засгийн газрын хувь оролцоо	6,404,868,517.03	7,328,329,597.54	(48,600,563.00)	7,279,729,034.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,871,077,340.11	5,743,688,640.11	127,388,700.00	5,871,077,340.11
51101	Өмч: - төрийн	5,871,077,340.11	5,743,688,640.11	127,388,700.00	5,871,077,340.11
512	Хуримтлагдсан үр дүн	533,791,176.92	1,584,640,957.43	(175,989,263.00)	1,408,651,694.43
51210	Өмнөх үеийн үр дүн	533,791,176.92	538,912,896.92	-	538,912,896.92
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,045,728,060.51	(175,989,263.00)	869,738,797.51
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,442,278,353.03	7,346,103,201.54	(48,600,563.00)	7,297,502,638.54

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/			
		2015.12.31 Өмнөх оны гүйцэтгэл	2016.12.31 Тайлант оны гүйцэтгэл	Залруулга	Аудит хийгдсэн Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,013,693,118.17	5,249,144,884.99	(115,433,262.00)	5,133,711,622.99
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	986,962,018.87	1,427,854,410.63	(115,433,262.00)	1,312,421,148.63
120	Нийтлэг татварын бус орлого	986,962,018.87	1,427,854,410.63	(115,433,262.00)	1,312,421,148.63
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	986,962,018.87	1,427,854,410.63	(115,433,262.00)	1,312,421,148.63
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	986,962,018.87	1,095,665,958.13	-	1,095,665,958.13
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		332,188,452.50	(115,433,262.00)	216,755,190.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,026,731,099.30	3,821,290,474.36	-	3,821,290,474.36
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,976,722,690.00	3,545,294,539.36	-	3,545,294,539.36
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,976,722,690.00	3,545,294,539.36	-	3,545,294,539.36
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	50,008,409.30	275,995,935.00	-	275,995,935.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		275,995,935.00	-	275,995,935.00
131106	Төсвийн урамшуулал	50,008,409.30		-	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,920,072,645.94	4,203,416,824.48	3,231,086.00	4,206,647,910.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,920,072,645.94	4,203,416,824.48	3,231,086.00	4,206,647,910.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,873,016,721.17	3,563,969,539.48	3,231,086.00	3,567,200,625.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,085,534,047.68	2,138,419,377.68	-	2,138,419,377.68
210101	Үндсэн цалин	1,339,608,374.68	1,350,231,052.59	-	1,350,231,052.59
210102	Нэмэгдэл	630,980,073.00	677,308,325.09	-	677,308,325.09
210103	Унаа хоолны хөнгөлөлт	114,945,600.00	110,880,000.00	-	110,880,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	235,194,489.99	232,929,431.00	-	232,929,431.00
210201	Тэтгэврийн даатгал	222,096,089.39	148,738,738.00	-	148,738,738.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,626,877.10	16,946,604.00	-	16,946,604.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,274,600.10	21,183,254.00	-	21,183,254.00
210204	Ажилгүйдлийн даатгал	647,723.10	4,187,349.00	-	4,187,349.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,549,200.30	41,873,486.00	-	41,873,486.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,795,000.00	-	-	-
210304	Байрны түрээс	3,795,000.00	-	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	63,097,334.70	73,131,683.20	-	73,131,683.20
210401	Бичиг хэрэг	37,160,371.00	31,767,323.00	-	31,767,323.00
210402	Тээвэр, шатахуун	15,722,850.00	18,515,450.00	-	18,515,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,402,021.70	8,660,042.20	-	8,660,042.20
210404	Ном, хэвлэл	733,400.00	-	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,078,692.00	14,188,868.00	-	14,188,868.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,883,433.00	32,649,448.15	(2,169,800.00)	30,479,648.15
210601	Багаж, техник, хэрэгсэл	68,000.00	-	-	-
210604	Урсгал засвар	16,815,433.00	32,649,448.15	(2,169,800.00)	30,479,648.15
2107	Томилолт, зочны зардал	103,712,498.00	51,284,415.00	-	51,284,415.00
210701	Гадаад албан томилолт	24,960,516.00	-	-	-
210702	Дотоод албан томилолт	62,918,600.00	51,284,415.00	-	51,284,415.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	15,833,382.00	-	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	678,388,652.10	538,739,726.85	(4,730,000.00)	534,009,726.85
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	473,635,010.10	316,359,382.35	(4,730,000.00)	311,629,382.35
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,924,000.00	4,621,025.00	-	4,621,025.00
210803	Даатгалын үйлчилгээ		118,800.00	-	118,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	354,280.00	233,000.00	-	233,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	41,000.00	-	-	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,596,900.00	3,350,400.00	-	3,350,400.00
210807	Газрын төлбөр	2,200,000.00	5,500,000.00	-	5,500,000.00

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	191,637,462.00	208,557,119.50	-	208,557,119.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	686,411,265.70	496,815,457.60	10,130,886.00	506,946,343.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	437,475,114.53	278,495,935.00	-	278,495,935.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,141,000.00		-	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	234,795,151.17	218,319,522.60	10,130,886.00	228,450,408.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,047,055,924.77	639,447,285.00	-	639,447,285.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	331,907,640.00	408,048,838.00	-	408,048,838.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	247,115,740.00	362,701,426.00	-	362,701,426.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	84,791,900.00	45,347,412.00	-	45,347,412.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,715,148,284.77	231,398,447.00	-	231,398,447.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	264,268,361.61		-	
213304	Хөрөнгийн	2,450,879,923.16	231,398,447.00	-	231,398,447.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(1,906,379,527.77)	1,045,728,060.51	(118,664,348.00)	927,063,712.51
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-	57,324,915.00	57,324,915.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз			57,324,915.00	57,324,915.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-	(57,324,915.00)	(57,324,915.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(1,906,379,527.77)	1,045,728,060.51	(175,989,263.00)	869,738,797.51

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансн ы код	Үзүүлэлт	2015.12.31 Өмнөх оны гүйцэтгэл	2016.12.31 Тайлант оны гүйцэтгэл	Залруулга	Аудит хийгдсэн Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	10,639,373,739.80	8,838,317,829.83	-	8,838,317,829.83
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,612,642,640.50	5,017,027,355.47	-	5,017,027,355.47
120009	Бусад орлого	6,612,642,640.50	5,017,027,355.47	-	5,017,027,355.47
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,026,731,099.30	3,821,290,474.36	-	3,821,290,474.36
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,976,722,690.00	3,545,294,539.36	-	3,545,294,539.36
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,976,722,690.00	3,545,294,539.36	-	3,545,294,539.36
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	50,008,409.30	275,995,935.00	-	275,995,935.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		275,995,935.00	-	275,995,935.00
131106	Төсвийн урамшуулал	50,008,409.30		-	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	10,639,373,739.80	8,838,317,829.83	(35,486,900.00)	8,802,830,929.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,639,373,739.80	8,838,317,829.83	(35,486,900.00)	8,802,830,929.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,670,805,557.69	3,413,241,636.36	(35,486,900.00)	3,377,754,736.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,085,571,085.53	2,146,819,377.68	-	2,146,819,377.68
210101	Үндсэн цалин	1,339,645,412.53	1,358,631,052.59	-	1,358,631,052.59
210102	Нэмэгдэл	630,980,073.00	677,308,325.09	-	677,308,325.09
210103	Унаа хоолны хөнгөлөлт	114,945,600.00	110,880,000.00	-	110,880,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	235,130,443.83	233,177,002.78	-	233,177,002.78
210201	Тэтгэврийн даатгал	222,032,043.23	220,187,422.40	-	220,187,422.40
210202	Тэтгэмжийн даатгал	2,626,877.10	2,605,053.25	-	2,605,053.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,274,600.10	3,274,600.09	-	3,274,600.09
210204	Ажилгүйдлийн даатгал	647,723.10	642,341.88	-	642,341.88
210205	Эрүүл мэндийн даатгал	6,549,200.30	6,467,585.16	-	6,467,585.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол	3,795,000.00	-	-	-
210304	Байрны түрээс	3,795,000.00		-	
2104	Хангамж, бараа материалын зардал	57,993,162.70	71,022,643.20	-	71,022,643.20
210401	Бичиг хэрэг	33,126,799.00	27,559,695.00	-	27,559,695.00
210402	Тээвэр, шатахуун	13,012,850.00	18,515,450.00	-	18,515,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,402,021.70	8,660,042.20	-	8,660,042.20
210404	Ном, хэвлэл	769,400.00		-	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,682,092.00	16,287,456.00	-	16,287,456.00
2105	Нормативт зардал	2,250,000.00	-	-	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,250,000.00		-	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	89,581,813.00	33,838,448.15	(1,189,000.00)	32,649,448.15
210601	Багаж, техник, хэрэгсэл	68,837,380.00		-	
210604	Урсгал засвар	20,744,433.00	33,838,448.15	(1,189,000.00)	32,649,448.15
2107	Томилолт, зочны зардал	92,804,048.00	54,584,425.00	-	54,584,425.00
210701	Гадаад албан томилолт	24,960,516.00		-	
210702	Дотоод албан томилолт	54,346,010.00	54,584,425.00	-	54,584,425.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	13,497,522.00		-	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	652,063,890.10	595,303,804.55	(34,297,900.00)	561,005,904.55
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	473,635,010.10	321,048,282.35	(1,930,000.00)	319,118,282.35
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,924,000.00	19,192,025.00	(14,571,000.00)	4,621,025.00
210803	Даатгалын үйлчилгээ		118,800.00	-	118,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	354,280.00	233,000.00	-	233,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	41,000.00		-	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	29,189,400.00	28,911,700.00	(17,796,900.00)	11,114,800.00
210807	Газрын төлбөр	2,200,000.00	5,500,000.00	-	5,500,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	142,720,200.00	220,299,997.20	-	220,299,997.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	451,616,114.53	278,495,935.00	-	278,495,935.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	437,475,114.53	278,495,935.00	-	278,495,935.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,141,000.00		-	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,968,568,182.11	5,425,076,193.47	-	5,425,076,193.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	331,907,640.00	408,048,838.00	-	408,048,838.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж,	247,115,740.00	362,701,426.00	-	362,701,426.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	84,791,900.00	45,347,412.00	-	45,347,412.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,636,660,542.11	5,017,027,355.47	-	5,017,027,355.47
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,185,629,758.95	4,785,628,908.47	-	4,785,628,908.47
213304	Техник хяналт	2,451,030,783.16	231,398,447.00	-	231,398,447.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	-	35,486,900.00	35,486,900.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН	-	-	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН	-	-	35,486,900.00	35,486,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	35,486,900.00	35,486,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-	35,486,900.00	35,486,900.00
222001	Тоног төхөөрөмж			35,486,900.00	35,486,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	-	(35,486,900.00)	(35,486,900.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний			-	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн			-	

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Залруулга	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,895,734,878.34		2,440,170,704.69		8,335,905,583.03	0.00	8,335,905,583.03
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,895,734,878.34	0.00	2,440,170,704.69	0.00	8,335,905,583.03	0.00	8,335,905,583.03
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	(24,657,538.23)		(1,906,379,527.77)		(1,931,037,066.00)	0.00	(1,931,037,066.00)
C08	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,871,077,340.11	0.00	533,791,176.92	0.00	6,404,868,517.03	0.00	6,404,868,517.03
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,871,077,340.11	0.00	533,791,176.92	0.00	6,404,868,517.03	0.00	6,404,868,517.03
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			5,121,720.00		5,121,720.00	0.00	5,121,720.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,871,077,340.11	0.00	538,912,896.92	0.00	6,409,990,237.03	0.00	6,409,990,237.03
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн			862,838,997.51		918,339,360.51	(48,600,563.00)	869,738,797.51
D09	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,871,077,340.11	0.00	1,401,751,894.43	0.00	7,328,329,597.54	(48,600,563.00)	7,279,729,034.54

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Төсвөөс хэмнэсэн +, хэтэрсэн-	Гүйцэтгэлийн хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,631,680,800.00	3,545,294,539.36	86,386,260.64	97.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,631,680,800.00	3,545,294,539.36	86,386,260.64	97.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,159,913,300.00	3,137,245,701.36	22,667,598.64	99.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,148,068,500.00	2,146,819,377.68	1,249,122.32	99.9
210101	Үндсэн цалин	1,350,633,900.00	1,358,631,052.59	(7,997,152.59)	100.6
210102	Нэмэгдэл	686,554,600.00	677,308,325.09	9,246,274.91	98.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	110,880,000.00	110,880,000.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	240,218,300.00	233,177,002.78	7,041,297.22	97.1
210201	Тэтгэврийн даатгал	240,218,300.00	233,177,002.78	7,041,297.22	97.1
2104	Хангамж, бараа материалын зардал	71,032,400.00	71,022,643.20	9,756.80	100.0
210401	Бичиг хэрэг	28,787,000.00	27,559,695.00	1,227,305.00	95.7
210402	Тээвэр, шатахуун	14,938,100.00	18,515,450.00	(3,577,350.00)	123.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,867,500.00	8,660,042.20	5,207,457.80	62.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,439,800.00	16,287,456.00	(2,847,656.00)	121.2
2105	Нормативт зардал	2,250,000.00	-	2,250,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,250,000.00	-	2,250,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,451,400.00	33,838,448.15	3,612,951.85	90.4
210604	Урсгал засвар	37,451,400.00	33,838,448.15	3,612,951.85	90.4
2107	Томилолт, зочны зардал	54,585,000.00	54,584,425.00	575.00	100.0
210702	Дотоод албан томилолт	54,585,000.00	54,584,425.00	575.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	603,807,700.00	595,303,804.55	8,503,895.45	98.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлч	321,206,200.00	321,048,282.35	157,917.65	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	20,000,000.00	19,192,025.00	807,975.00	96.0
210803	Даатгалын үйлчилгээ	2,841,300.00	118,800.00	2,722,500.00	4.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	579,800.00	233,000.00	346,800.00	40.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	76,000.00	-	76,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	33,304,400.00	28,911,700.00	4,392,700.00	86.8
210807	Газрын төлбөр	5,500,000.00	5,500,000.00	-	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	220,300,000.00	220,299,997.20	2.80	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00	2,500,000.00	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00	2,500,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	471,767,500.00	408,048,838.00	63,718,662.00	86.5
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	24,669,200.00	-	24,669,200.00	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	24,669,200.00	-	24,669,200.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	447,098,300.00	408,048,838.00	39,049,462.00	91.3
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуул	364,746,100.00	362,701,426.00	2,044,674.00	99.4
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэ	82,352,200.00	45,347,412.00	37,004,788.00	55.1
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,631,680,800.00	3,545,294,539.36	86,386,260.64	97.6
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,631,680,800.00	3,545,294,539.36	86,386,260.64	97.6
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,631,680,800.00	3,545,294,539.36	86,386,260.64	97.6
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	145.00	144.00	1.00	99.3
620001	Удирдах ажилтан	9.00	12.00	(3.00)	133.3
620002	Гүйцэтгэх ажилтан	136.00	132.00	4.00	97.1
620003	Үйлчлэх ажилтан			-	
620004	Гэрээт ажилтан			-	